



**“УЛААН АСРЫН ЗҮҮД” ЗОХИОЛЫН ДАЛД ЗҮЙРЛЭЛИЙН ОРЧУУЛГЫН
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Х.Номлосаран⁴⁵

Х.Нандин-Эрдэнэ⁴⁶

***Abstract:** A metaphor is a form of composition that implicitly compares one thing to another. The more rational the analogy, the more concise, understandable and graphic the expression can be. Therefore, implicit metaphors or metaphors belong to cognitive sciences such as psychology, linguistics, and culture. Metaphorical sentences and idioms require certain skills to translate because of the culture of the language. Mongolians have a long history of developing and applying rich translation practices and theories. One of their major confirmations is Khasbu's "Newly translated «The Dream of the Red Chamber»". Currently, academics are still studying the introduction and interpretation method of the novel "Newly translated «The Dream of the Red Chamber»" and the translation of the poem. This time, we observe and summarize the translation of metaphorical sentences and idioms in Khasbu's "Newly translated «The Dream of the Red Chamber»".*

***Түлхүүр үг:** “Хун Лоумэн бичиг”, орчуулах арга, үгчилсэн орчуулга, утгачилсан орчуулга, хэлц үг*

1. Хасбуугийн “Шинээр орчуулсан «Улаан асрын зүүд»” бүтээлийн судалгаа

“Өглөг баясгалантын гэрийн эзэн бичигт ховдог хөвгүүн” Хасбуу “Улаан асрын зүүд” романыг утга төгөлдөр, уран яруу, уншихад ойлгомжтойгоор монгол бичгээр хөрвүүлж, улмаар цохолборлон бинтлэх бүхий л аргыг бүтээлчээр хэрэглэсэн нь Монгол, Хятадын уран зохиолын харилцааны түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэжээ. Дуун хөрвүүлэгч Хасбуу уг бүтээлийг орчуулахдаа Цао Шюэчиний билиг авьяасыг хүндлэн биширч байснаас гадна түүний дэвшилтэт үзэл санааг дэмжин, сайшааж байснаа “Шинээр орчуулсан Улаан асрын зүүд” номын 40-р бүлгийн цохолборт өгүүлсэн байдаг. (Хасбуу Х. Х., 2013, хууд. 526)

2016 онд Өвөр монголын судлаач Эрхэмбаярын “Хасбуугийн “Шинэ орчуулсан «Улаан асрын зүүд»”-ний судалгааны тойм” өгүүлэлд уг зохиолыг шүүмж, туурвил зүй, зохиогдсон цаг хугацаа болон Хасбуугийн намтар зэрэг олон талаас судалсаар ирснийг жишээ баримтыг хамт тайлбарлан өгүүлжээ. Тухайлбал 1972 оноос эхлэн Өвөр монголын эрдэмтэн Б.Гэрэлт, Баянхишиг нар тус зохиолыг хэвлүүлэх, он цагийг нь тодорхойлох зэрэг судалгааг хийж иржээ. (额尔根巴雅尔, 2016) 1979 онд Өвөр монголын эрдэмтэн И Линьжэнь (亦邻真) “Шинээр орчуулсан «Улаан асрын зүүд»-ний цохолбор” (新译红楼梦回批) -ыг хятад хэлээр

⁴⁵ МУИС, ШУС, МХХШТ, доктор

⁴⁶ МУИС, ШУС, АСТ, доктор

хэвлүүлж өмнөтгөл хэсэгт уг номын тухайн дэлгэрэнгүй тайлбар бичжээ. Баянхишиг, Залгаа зэрэг эрдэмтэн Хасбуугийн намтрын талаарх өгүүллийг хэвлүүлэв.

Эрдэмтэн Д.Болормаа “Монгол уран зохиол дахь цохолборлон бинтлэх арга” номд тус зохиолын цохолборлон бинтлэх аргын судалгааг дэлгэрэнгүй хийсэн юм. Өдгөө уг бүтээлийг цохолборлон бинтлэх аргын судалгаа, уран сайхны шүүмж судлал зэрэг чиглэлийн судалгаа зонхилж байдаг. 2023 онд судлаач Ц.Ичинхорлоо уг номын бүтцийн харьцуулалт, орчуулгын уран сайхны ажиглалт болон харь үгийн судалгаанд дүн шинжилгээ хийсэн нь монгол улс дахь уг бүтээлийн талаарх судалгааг өргөжүүлэхэд тодорхой хэмжээний ач холбогдолтой болжээ.

Монгол Улсын Үндэсний номын сан 1927 онд анх баригдаж байхад тухайн үед “Баримт бичиг, материалын судалгааны хүрээлэн” нэртэй байжээ. “Баримт бичгийн судалгааны хүрээлэн” байгуулагдахад “Богд хааны музей” болон хувийн сан хөмрөгөөс 8000 гаруй гар бичмэл, номыг Үндэсний номын санд цуглуулсны дотор “Хунлоумэн бичиг” гар бичмэлийг цуглуулсан гэдэг. (Ичинхорлоо, 2023)

1956 онд Бүх хятадын цөөн тоот үндэстний хэл бичгийн хээрийн судалгааны баг дахь Монгол хэлний бүлгийн судлаачид Зостын чуулганаас “Шинэ орчуулсан «Улаан асрын зүүд»”-ний гар бичмэлийг олж авч байжээ. Улмаар 1957 онд Өвөр монголын Их сургууль байгуулагдахад тус сургуулийн номын санд хандивлажээ.

Өдгөө тус номын гар бичмэл нь Өвөр монголд таван ширхэг, Монгол улсын Үндэсний Төв номын санд нэг хувь тус тус хадгалагдаж байна.

2009 онд эрдэмтэн С.Хөвсгөл “Улаан асрын зүүд” бүтээлийг монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлснийг энэ удаагийн судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож ашиглав.

2. “Улаан асрын зүүд” зохиолын далд зүйрлэлийн орчуулгын харьцуулсан судалгаа

Далд зүйрлэл бол нэг зүйлийг нөгөө зүйлтэй далд хэлбэрээр зүйрлэж буй найруулгын нэг хэлбэр юм. Зүйрлэл нь оновчтой байх тусам илэрхийлэл нь товч, ойлгомжтой, уран дүрслэлтэй байж чаддаг. Тиймээс далд зүйрлэл буюу далд зүйрлэл нь сэтгэл судлал, хэл шинжлэл, соёл зэрэг танихуйн шинжлэх ухаанд багтдаг. Далд зүйрлэл бүхий өгүүлбэр болон хэлц үг зэрэгт тухайн хэлний соёл оршдог тул тэдгээрийг орчуулахад тодорхой ур чадвар шаарддаг.

Бид 1996 онд Хятадын Уран зохиолын хэвлэлийн газраас хэвлүүлсэн “Улаан асрын зүүд”-ний хятад эх (曹雪芹, 1996) болон 2014 онд Хятадын Урлаг судлалын Хүрээлэн ба Улаан асрын зүүд судлалын хүрээлэн хамтран хэвлэсэн “Улаан асрын зүүд” зохиолоос эхний эхний бүлэгт багтсан далд зүйрлэл бүхий өгүүлбэрийг түүвэрлэн авч “Хунлоумэн бичиг” (Хасбуу) орчуулга, 2009 онд эрдэмтэн С.Хөвсгөлийн кирилл рүү хөрвүүлсэн “Улаан асрын зүүд” болон 2015 онд БНХАУ-ын ЭСЯ-ны Соёлын хэлтсээс гаргасан “Улаан асрын зүүд”-ний (Шюэчин, 2018) орчин цагийн монгол хэлээр орчуулсан хувилбарт ажиглалт хийсэн юм. Ингэхдээ зүйрлэлийн эх үүсвэр нь тодорхой болон зүйрлэлийн эх үүсвэр нь далд хэлбэртэй өгүүлбэрүүдийг сонгон авсны дээр хэлц үгийн жишээг мөн оруулсан болно.

- Зүйрлэлийн эх үүсвэр нь тодорхой өгүүлбэр

Зүйрлэлийн эх үүсвэр нь тодорхой (source) гэдэг нь адилтгал болж буй тухайн эд зүйл ба юмс үзэгдэл нүдэнд харагдахуйц бодитой зүйл болохыг хэлнэ. Жишээлбэл: Завь шиг хэлбэртэй навч. Уг өгүүлбэрийн адилтгал болж буй завь нь нүдэнд харагдахуйц бодитой зүйл тул зүйрлэлийн эх үүсвэр нь тодорхой гэсэн үг юм. “Улаан асрын зүүд” зохиолоос дараах өгүүлбэрийг сонгон авч орчуулгыг нь харьцуулан ажиглав.

1) Хятад өгүүлбэр: 膝下无儿 (膝-өвдөг, 下-дор, 无-үгүй, 儿- хүү)

Үндэсний бичгийн олон улсын галиг: ebüdüg-dor köbegün ügei

Кирилл хөрвүүлэг: *Өвдөг дор хөвгүүн үгүй*

Кирилл орчуулга: *хүүтэй болж чадсангүй*

膝下无儿-өвдөг дор хөвгүүнгүй. (“膝下” ханзны утга нь “өвдөг дор”)

Хятад өгүүлбэрийн утгаас үзэхэд нялх балчир хөвгүүнгүй болохыг “өвдөгнөөс доогуур татах нялх балчир хүүгүй” гэсэн утгыг нүдэнд харагдах бодит байдалтай зүйрлэн өгүүлжээ. Тэгвэл уг зүйрлэлийг монгол бичгийн орчуулгад шууд үгчлэн орчуулсан (*Өвдөг дор хөвгүүн үгүй*) бол кирилл орчуулгад утгачлан (*хүүтэй болж чадсангүй*) орчуулжээ. Хоёр орчуулгыг харьцуулахад үгчилсэн буюу шууд орчуулга нь далд зүйрлэлийг тэр чигээр нь оновчтой илэрхийлсэн бол утгачилсан орчуулгад эх өгүүлбэрийн далд зүйрлэл нь үгүй болсноор хятад өгүүлбэрт багтсан соёл, сэтгэлгээний онцлог илрэх боломжгүй болсон байна.

2) Хятад өгүүлбэр: 不觉朦朦胧睡去 (不觉-санамсаргүй 朦朦胧-сааралтан бүдгэрэх 睡去-зүүрмэглэн)

Үндэсний бичгийн олон улсын галиг: sanamsar ügei jirub jarub nigen yajar-du kürcü

Кирилл хөрвүүлэг : *санамсаргүй жирув жирув нэгэн газарт хүрч*

Кирилл орчуулга: *санамсаргүй зүүрмэглэснээ, нэгэн газарт хүрч*

Хятад өгүүлбэрийн утгаас үзэхэд “зэрвэс зүүрмэглэн, нойрондоо нэгэн газарт хүрч” гэсэн утгыг зүйрлэн өгүүлжээ. Тэгвэл уг зүйрлэлийг монгол бичгээр зүүрмэглэх гэдэг үгийг гээн орчуулсан (*санамсаргүй жирув жирув нэгэн газарт хүрч*) бол кирилл орчуулгад “зэрвэс зэрвэс” гэсэн утгатай хятад үгийг орчуулаагүй байна. (*санамсаргүй зүүрмэглэснээ, нэгэн газарт хүрч*) орчуулжээ. Хоёр орчуулгыг харьцуулахад кирилл орчуулга нь зүйрлэл бүхий үгийг гээн утгачлан орчуулсан бол монгол бичгийн орчуулгад “жирув, жирув” гэж тодорхой бус үзэгдлийг төлөөлүүлэн үгчлэн орчуулжээ.

3) Хятад өгүүлбэр: 茫茫大士、渺渺真人 (茫茫-бүрэг бараг 大士- багштан 渺渺-жирэв жирэв 真人- арш)

Үндэсний бичгийн олон улсын галиг: baruу būruу bayси jirub jarub arsi

Кирилл хөрвүүлэг: *Бараг Бүрэг багш жирув жирув ариш*

Кирилл орчуулга: *Энэ биш хэмээх хувилгаан болон, Тэр биш хэмээх шидтэн*

Хятад өгүүлбэрт ямар нь тодорхойгүй багш, арш хоёрыг дүрслэн өгүүлжээ. Үнэхээр ч зохиолд хуушаан, бумба хоёр аль сүм хийдийн, ямар лам нар, хаанаас хаа хүрч яваа гэх мэтийг тухай тодорхой дүрсэлдэггүй. Харин үйл явдлын эгзэгтэй мөчид гэнэт гарч ирээд

шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг тул тийнхүү “бараг бүрэг багш, жирув, жирув ари” гэж тодорхой бус байдлыг нь зүйрлэн нэрлэжээ.

Тэгвэл уг зүйрлэлийг монгол бичгийн орчуулгад шууд үгчлэн орчуулсан (*бараг, бүрэг, жирув, жирув*) бол кирилл орчуулгад утгачлан (*Энэбиш, Тэр биш*) орчуулжээ. Хоёр орчуулгыг харьцуулахад үгчилсэн буюу шууд орчуулга нь далд зүйрлэлийг тэр чигээр нь оновчтой илэрхийлснээр дүрийн онцлог илэрч чадсан бол утгачилсан орчуулга нь зүйрлэл биш харин оноосон нэрээр дүйцүүлэн орчуулснаар тухайн дүрийн онцлог илэрч гараагүй байна. (Монгол хэлэнд Энэбиш, Тэрбиш зэрэг хүний нэр түгээмэл бий.)

Зүйрлэлийн эх үүсвэр нь тодорхой өгүүлбэрийн орчуулгын жишээг харьцуулж үзэхэд үндэсний бичгийн орчуулгад үгчилсэн буюу шууд орчуулах аргыг хэрэглэсэн бол кирилл орчуулгад утгачлах, дүйцүүлэх аргыг ашигласан байв. Тэдгээр орчуулгыг хятад эхтэй нь харьцуулахад үгчилсэн орчуулга нь тухайн хэлний соёл, дүрийн онцлог зэргийг бүрэн илэрхийлж байсан бол харин утгачилсан орчуулгад тэдгээр соёл, онцлог зэрэг нь илрээгүй байв.

- **Зүйрлэлийн эх үүсвэр нь далд өгүүлбэр**

Зүйрлэлийн эх үүсвэр нь далд гэдэг нь адилтгал болж буй тухайн эд зүйл, ба юмс үзэгдэл нүдэнд харагдахуйц бодитой бус хийсвэр зүйл болохыг хэлнэ. Жишээлбэл: “Улаан асрын зүүд” зохиолын баатруудын нэр нь тухайн дүрийнхээ зан чанар онцлогийг илэрхийлсэн байдаг.

- 4) Хятад өгүүлбэр: 枉入红尘若许年 (枉入-дэмий явав, 红尘 -улаан тоос, 若许年-өчнөөн жил)

Үндэсний бичгийн орчуулга: kümün-ü yirtinčü-yin ulayan toyusun- dor öčinen jil yababai. .

Кирилл бичгийн хөрвүүлэг: *Хүний ертөнцийн улаан тоосонд өчнөөн жил явбай*

Кирилл бичгийн орчуулга: *Энгийн ертөнцийн улаан тоосонд дэмий баахан амьдрав*
Уг өгүүлбэрт багтсан “*红尘*” буюу “улаан тоос” гэсэн ханзны анхны утга нь “хүн малын хөлд гишгэгдсэн улаан тоос” гэсэн утгатай байгаад хожим “зовлон жаргал ээлжилсэн хүний орчлон” гэсэн утгыг илэрхийлдэг болжээ. Зохиолд энэхүү үгийн зүйрлэлийг утгачлалгүй шууд орчуулсан байна. “Монгол хэлний их тайлбар толь”-д *улаан тоосыг* “хорвоо ертөнцийн хэрэг явдал” гэж тайлбарласан нь хятад утгатай таарч байв.

Тиймээс үндэсний бичиг болон кирилл орчуулгад хүний орчлонгийн жаргал, зовлон гэсэн утга бүхий “*红尘*” ханзыг “улаан тоос” гэж шууд үгчлэн орчуулсан нь далд утгыг илэрхийлсэн оновчтой орчуулга болжээ.

- **Хэлц үг үгийн орчуулгын жишээ**

Хэлц үг бол тухайн ард түмний соёл, сэтгэлгээний онцлогийг илэрхийлсэн далд зүйрлэл бүхий хэл зүйн өвөрмөц хэлбэр юм. Өөрөөр хэлбэл “Өвөрмөц хэлц гэдэг бол утгын хувьд бүрдүүлж байгаа үг тус бүрийн нь цөм утга алдарч, нийлэн нэгдэж, нэгэн ухагдахуун, утга санаа илэрхийлсэн, тухайн ард түмний сэтгэхүй, сэтгэлгээ нэвт шингэсэн, аж ахуй, бодит амьдрал , хэв ёс, зан заншил, шашин шүтлэг, үзэл бодол гэх зэргийн гүн тусгал болсон тогтвортой нийлэмж үг юм.” (Д., 2006)

Бид “Улаан асрын зүүд” зохиолын 1-р бүлэгт багтсан хэлц үгийн орчуулгыг харьцуулан ажиглав.

5) Хятад өгүүлбэр: 饴甘饘肥 (饴-идэх, 甘-амттан, 饘-амсах, 肥-тарган)

Үндэсний бичгийн олон улсын галиг: amtatan-i idejü taryun-i amsaju.

Кирилл хөрвүүлэг: *амттаныг идэж, тарганыг амсаж*

Кирилл орчуулга: *Тос маханд бялхаж*

Хятад өгүүлбэрийн утгаас үзэхэд амттаныг идэж, тарганыг амсан “өлсөж, цангахын зовлонгүй элбэг, хангалуун” гэсэн утгыг нүдэнд харагдах бодит байдалтай зүйрлэн өгүүлжээ. Тэгвэл уг зүйрлэлийг үндэсний бичгийн орчуулгад шууд үгчлэн орчуулсан бол кирилл орчуулгад утгачлан (*Тос маханд бялхаж*) орчуулжээ. Хоёр орчуулгыг харьцуулахад үгчилсэн буюу шууд орчуулга нь далд зүйрлэлийг тэр чигээр нь оновчтой илэрхийлсэн бол утгачилсан орчуулгад ч мөн далд зүйрлэл илэрчээ.

6) 茅椽蓬牖 (茅-улалж өвс, 椽-дам мод, 蓬-хоёр наст ургамал, 牖-цонх)

Үндэсний бичгийн олон улсын галиг: ulaljın ger, ebsung suru

Кирилл хөрвүүлэг: *улалжин гэр, өвсөн сүрү*

Кирилл орчуулга: *элбэг дэлбэг гэр, цаасан цонх*

Хятад өгүүлбэрийн утгаас үзэхэд “өвсөн дээвэр, өвсөн хүрээ” бүхий толгой хоргодох оромж гэсэн утгыг нүдэнд харагдах бодит байдалтай зүйрлэн өгүүлжээ. Тэгвэл уг зүйрлэлийг үндэсний бичгийн орчуулгад утгачлан орчуулсан (*улалжин гэр, өвсөн сүрү*) бол кирилл орчуулгад хятад өгүүлбэрийн үндсэн утгыг ташаа (*элбэг дэлбэг гэр, цаасан цонх*) орчуулжээ. Монгол бичгийн орчуулга дахь “улалж” болон “сүрү” гэсэн хоёр үгийг “Монгол хэлний их тайлбар толь”-д дараах байдлаар тайлбарлажээ. “Улалж”-ийг “Хотгор газар ургадаг, иш өндөр, олон наст өвс; өлөн өвс, ширэг” гэсэн бол “сүрү” буюу “сүр”-ийг “Цагаан идээ хатаахаар босгосон өндөр тавиур” гэж тайлбарлажээ. Тиймээс “*улалжин гэр, өвсөн сүрү*” гэдэг үг нь өвсөн дээвэр, өвсөн хүрээтэй байшинг бодитоор дүрсэлснээс гадна цаагуураа тарчиг ядуу гэсэн утгыг далд хэлбэрээр илэрхийлжээ. Монгол хэлэнд ч мөн “хатавчаар нь нар сар гийж, хотонд нь навч цэцэг ургаг” гэж үгээгүй ядуу явахыг ёрлосон хэллэг бий. Гэтэл орчин цагийн монгол хэлний найруулга бүхий кирилл орчуулгад “элбэг дэлбэг гэр” гэж ташаа орчуулснаар Ц.Дамдинсүрэн гуайн “Үгийг нэмж хасах гайгүй хэрэг. Утгыг нэмж хасвал гэмтэй хэрэг. Үг ба өгүүлбэрт халдаж болно. Гол утгад халдаж болохгүй.” (Ц., 1998) гэсэн зарчимтай үл нийцжээ.

Хэлц үгийн орчуулгыг харьцуулахад үндэсний бичгийн орчуулга нь шууд буюу үгчлэн орчуулсан бол кирилл бичгээр орчуулахдаа үгчлэхээр гадна утгачилж орчуулжээ. Гэвч утгачлан оруулахдаа утгыг гуйвуулж ташаа орчуулсан байна.

Дүгнэлт

Хятадын сонгодог бүтээлийн нэг Цао Шюэ чиний “Улаан асрын зүүд” үргэлжилсэн үгийн зохиолын Хасбуугийн үндэсний бичгээр орчуулсан “Хун лоумэн бичиг”, БНХАУ-ын Элчин Сайдын яамнаас гаргасан “Улаан асрын зүүд” зохиолын кирилл орчуулгын эхний хоёр бүлэгт багтсан далд зүйрлэл өгүүлбэрийн төрлүүдээс зүйрлэлийн эх үүсвэр нь

тодорхой өгүүлбэр, зүйрлэлийн эх үүсвэр нь далд өгүүлбэр мөн хэлц үгийн жишээ зэргийг харьцуулан ажиглан дараах дүгнэлтийг хийв.

- Зүйрлэлийн эх үүсвэр нь тодорхой өгүүлбэрийн орчуулгын жишээг харьцуулж үзэхэд үндэсний бичгийн орчуулгад үгчилсэн буюу шууд орчуулах аргыг хэрэглэсэн бол кирилл орчуулгад утгачлах, дүйцүүлэх аргыг ашигласан байв. Тэдгээр орчуулгыг хятад эхтэй нь харьцуулахад үгчилсэн орчуулга нь тухайн хэлний соёл, дүрийн онцлог зэргийг бүрэн илэрхийлж байсан бол харин утгачилсан орчуулгад тэдгээр соёл, онцлог зэрэг нь илрээгүй байв.

- Хэлц үгийн орчуулгыг харьцуулахад үндэсний бичгийн орчуулга нь шууд буюу үгчлэн орчуулсан бол кирилл бичгээр орчуулахдаа үгчлэхээр гадна утгачилж орчуулжээ. Гэвч утгачлан оруулахдаа утгыг гуйвуулж ташаа орчуулсан байна.

Дээрхээс эцэслэн дүгнэхэд Хасбуугийн “Хун Лоумэн бичиг” бүтээл нь шууд орчуулах аргаар далд зүйрлэл болон соёл ахуйн онцлогтой үг, өгүүлбэрийг уран яруу, утга төгөлдөр, уншихад ойлгомжтой орчуулах боломжтойг батлан илтгэх сонгодог жишээ болжээ. Харин утгачлан орчуулах нь эх зохиолын онцлог болон хэлний соёл илрэхгүй байх гэмтэйг “Улаан асрын зүүд” зохиолын кирилл орчуулгаас харж болох юм.

Ном зүй

Ичинхорлоо, Ц. (2023). “Шинэ орчуулсан Улаан асрын зүүд”-ийн орчуулгын уран чадварт хийсэн ажиглалт. Орчуулгазүй, Боть 11, 106-116-р тал.

Хасбуу. (n.d.). Хун лоумэн бичиг

Хасбуу, Х. Х. (2013). Улаан асрын зүүд. Улаанбаатар

Ц., Д. (1998). Цэндийн Дамдинсүрэн. Бүрэн зохиол III. In Х. Д. Ц., Улаанбаатар

Шюэчин, Ц. (2018). Улаан асрын зүүд I. Улаанбаатар

曹雪芹. (1996). 红楼梦 I. 北京: 人文学出版社

额尔根巴雅尔. (2016). 哈斯宝《新译红楼梦》研究述评. 民族大学研究